БАТЛАВ.
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ДАРГА
Б.БОЛОР-ЭРДЭНЭ

Зам, тээврийн яамны дэргэдэх

Ёс зүйн дэд хорооны 2025 оны I-р

улиралын хурлын төлөвлөгөө

№01

Зохион байгуулах газар: Төрийн захиргааны удирдлагын газрын даргын өрөөнд

Хугацаа: ..... оны ... дугаар сарын ...-ны өдрийн .... цаг

№	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцах албан тушаалтан	Тайлбар
1.	Хэлэлцэх асуудал батлах	10 мин	Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд	
2.	Ёс зүйн дэд хорооны 2025 оны төлөвлөгөө батлах	20 минут	Ёс зүйн дэд хорооны гишүүд	
3.	Бусад асуудал	15 мин		

Боловсруулсан:

Ёс зүйн дэд хорооны нарийн бичиг Т.Орхонтамир

БАТЛАВ.
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА БӨГӨӨД ЁС ЗҮЙН ДЭД
ХОРООНЫ ДАРГА Б.БОЛОР-ЭРДЭНЭ

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 03 дугаар сарын 31-ны өдөр

№	Хийх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль сурталчлах ажлыг харьяа 2 агентлагийн хэмжээнд зохион байгуулах	1-2 дугаар улирал	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
2	Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудал сэдэвт сургалтыг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын Ёс зүйн хороотой хамтран зохион байгуулах	1 дүгээр улирал	Ёс зүйн хорооны дарга, нарийн бичиг
3	УИХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг сурталчлах ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулах	2-3 дугаар улиралд	Ёс зүйн дэд хороо
4	"Байгууллагын хэмжээнд мэндлэх хүндлэх өдөр" арга хэмжээ зохион байгуулах	2 дугаар улирал	Ёс зүйн дэд хорооны гишүүд
5	Байгууллагын соёл ёс зүйг дээшлүүлэх уулзалт арга хэмжээ зохион байгуулах /Яамны нэгж бүрд өглөөний уулзалт хийх/	3- 4дүгээр улирал	Ёс зүйн дэд хорооны гишүүд
6	Байгууллагын соёл, ёс зүйн байдалд үнэлгээ хийж, зөвлөмж өгөх.	3 дугаар улирал	Ёс зүйн дэд хорооны гишүүд
7	Байгууллага, хувь хүний соёлтой холбоотой /"Мэндлэх соёл", "Монголын уламжлалт зан заншил, харилцаа", "Хүн байхын учир" "Хувь хүний хөгжил, өөрийгөө бүтээх,өөрчлөх" "Хувь хүний харилцааны ур чадвар", "Хувцаслах соёл", "Төрийн албан хаагчийн харилцаа, хандлага" гэх мэт/ болон бусад хамаарах сэдвийн хүрээнд Зочин илтгэгч урьж сургалт зохион байгуулах	1-3 дугаар улирал	Ёс зүйн дэд хорооны гишүүд
8	Зам, тээврийн яамны албан хаагчдад "Төрийн албан хаагчийн болон улс төрийн албан хаагчийн ёс зүй" сэдвээр уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулах.	2 дугаар улирал	Ёс зүйн дэд хорооны гишүүд

9	УИХ-ын Ёс зүйн хорооноос зохион байгуулах "Ёс зүйн сургагч багш" бэлтгэх сургалтад албан хаагч хамруулах .	Жилдээ	Ёс зүйн дэд хорооны гишүүд
10	Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 51 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Салбар зөвлөлийн ажиллах, үйл ажиллагааг дүгнэх журам"-ыг ЗТЯ болон харьяа байгууллагын хүний нөөцийн мэргэжилтнүүдэд мэдээлэл өгөх	2 дугаар улирал	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
11	Гомдол, мэдээллийн дагуу албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан эсэх тухай асуудлыг хэлэлцэх, дүгнэлт гаргах, үйл ажиллагааг Ёс зүйн дэд хороонд тайлагнах, шаардлагатай тохиолдолд дүгнэлтийг Төрийн албаны салбар зөвлөлд танилцуулах.	Тухай бүр	Ёс зүйн дэд хороо
13	Шинээр томилогдсон алба хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалт зохион байгуулах.	2 дугаар улирал	Ёс зүйн дэд хорооны гишүүд, нарийн бичгийн дарга
14	Зам, тээврийн яамны харьяа байгууллага болох Иргэний нисэхийн ерөнхий газар, Төмөр замын газрын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг чадавхижуулах, Зөвлөмж өгөх ажлыг зохион байгуулах	2 дугаар улирал	Ёс зүйн дэд хорооны гишүүд
15	Ёс зүйн дэд хороонд гаргасан гомдол, мэдээлэл, дүгнэлт, хариуцлага тооцсон шийдвэрийг тухай бүр "Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэн, мэдээллийн санд оруулах.	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга.
16	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг дүгнэн, санал дүгнэлт гаргах	4 дүгээр улирал	Ёс зүйн дэд хорооны гишүүд

...oOo...

ТӨЛӨВЛӨСӨН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА: Т.ОРХОНТАМИР.

Ёс зүйн хорооны 2025 оны ... дугаар
сарын ...-ний өдрийн ... дугаар тогтоолын
нэгдүгээр хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн батлалсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0	0
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0,5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0,5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0,5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт бөглөсөн байдал[9]	0,5	0	0
Хэсгийн оноо				4	2	20
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гаргасан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	1	10
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	1	10
Хэсгийн оноо				3	3	30
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	1	10
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	0	0
Хэсгийн оноо				3	2	20
Үнэлгээний нийт оноо, хувь				10	7	70

$$\text{Эзлэх хувь} = \frac{\text{ҮХХ} + \text{ЁЗМ} + \text{ЁЗДХ}}{10} * 100\%$$

Тайлбар:

[1] Байгууллагын өөрийн болон харьяа, салбар байгууллагад өгсөн үнэлгээ.

[2] Авсан оноог 10-аар үржиж хувийн жинг тооцох ба нийт дүн 100-с хэтрэхгүй байна.

[3] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр".

[4] ЁЗХ-ны 2025 оны 04 дүгээр тогтоолоор батлалсан "Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт"-д нийцүүлэн батлалсан төлөвлөгөөг хавсарган ирүүлнэ.

[5] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар "Аргачлал батлах тухай" тогтоол.

[6] УИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн 2.1 дэх хэсэг, ЁЗХ-ны 2024 оны 05 дугаар тогтоолоор батлалсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 4.1.3, мөн оны 15 дугаар "Сургалтын агуулга, сэдэв батлах тухай" тогтоол.

[7] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3 дахь заалт.

[8] ЁЗХ-ны 2025 оны 06 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийг тооцох үнэлгээний аргачлал"-ын 8.3.3, мөн оны 07 дугаар "Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргах, шалган шийдвэрлэх талаар авах арга хэмжээний тухай" тогтоол.

[9]ЁЗХ-ны 2024 оны 13 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 3.8 дахь хэсэг, 2025 оны 08 дугаар "Загвар батлах тухай" тогтоол.

[10] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт.

[11] Мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг.

[12] Мөн хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалт.

[13] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.2.2 дахь заалт.

[14] Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1 дэх заалт.

[15] ЁЗХ-ны 2024 оны 13 тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлалсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил, тэдгээрт хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг хөтлөх, мэдээллийн цахим санг удирдах, хөгжүүлэх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх журам"-ын 4.4.3, 4.4.4 дэх заалт.

-oOo-

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 29 өдөр Дугаар А/86 Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.4.1, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны "Журам батлах тухай" 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 2.4, 3.8-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус яамны албан хаагчдаас авсан нээлттэй санал асуулгын дүнг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх "Ёс зүйн дэд хороо"-г дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	
Б.Болор-Эрдэнэ	Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	
Т.Орхонтамир	Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	
С.Мяндасмаа	Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга
Ц.Нэргүйбаатар	Автотээврийн бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч
Ц.Баяржаргал	Автотээврийн бодлого зохицуулалтын газрын шинжээч
Д.Баярмаа	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч
П.Часанжаргал	Төрийн захиргааны удирдлагын газрын шинжээч

2.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг тухай бүр төлөвлөн зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны дарга (Б.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

C3333C696

3.Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдэд улиралд нэг удаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргад (Н.Цэвэлмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн "Ёс зүйн зөвлөл шинэчлэн байгуулах тухай" А/35 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ 2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН "ТАЙЛАНГИЙН МАЯГТ"[1]

НЭГ. Товч танилцуулга[2]

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль болон Ёс зүйн хорооны батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-д заасны дагуу Зам, тээврийн яамны дэргэдэх "Ёс зүйн дэд хороо"-г Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн "Ёс зүйн дэд хороо байгуулах тухай" А/86 дугаар тушаалаар байгуулсан.

Зам, тээврийн яамны дэргэдэх "Ёс зүйн дэд хороо"-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэхээр хурлын төлөвлөгөөг батлуулан 2025 оны ёс зүйн дэд хорооны 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулж, төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг заасан хугацаанд хэрэгжүүлж, Ёс зүйн зөрчил, гомдлыг хүлээн авч холбогдох хариуг хүргүүлэн ажиллаж байна.

ХОЁР. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар

2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3]:

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийг сурталчлах ажлыг агентлагийн хэмжээнд зохион байгуулсан.

Зам, тээврийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороотой хамтран шинээр томилогдсон албан хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтыг улирал бүр зохион байгуулсан.

Мөн Ёс зүйн хороо, Удирдлагын академи хамтран 2025 оны 05 дугаар сарын 19-22-ны өдрүүдэд зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх сургалтад Зам, тээврийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмааг хамруулж амжиллтай сургагч багшаар бэлтгэн авсан ба Сургагч багш нь тус яамны харьяа Засгийн газрын хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагийн албан хаагч нарт "Төрийн албан хаагчийн ёс зүй болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх" талаарх сургалтыг 2025 оны төлөвлөгөөнд туссан хугацаанд сургалтыг зохион байгуулсан.

2025 онд шинээр Төмөр замын газар агентлаг байгуулагдсан ба шинээр байгуулагдсан Ёс зүйн дэд хороонд холбогдох арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч ажилласан.

Мөн Зам, тээврийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хороо нь Төрийн албаны тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай сургалтыг 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдөр Төмөр замын газарт зохион байгуулж агентлагийн нийт 23 албан хаагчийг хамруулсан.

Удирдлагын академийн Төрийн албаны сургууль, Ёс зүйн хороо хамтран 2025 оны 11, 12 дугаар сард зохион байгуулсан "Ёс зүй, хүний эрх" сэдэвт 16 цагийн сургалтад Ёс зүйн дэд хорооны гишүүд хамрагдсан.

---

[1] Маягтын дагуу тайланг 5 хуудаснаас ихгүй, товч үр дүнг нэгтгэн ирүүлнэ.

[2] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[3] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

Түүнчлэн Төрийн албаны зөвлөлөөс "Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл" аяныг салбарын хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг батлан төлөвлөгөөнд туссан арга хэмжээн салбарын хэмжээнд зохион байгуулж ажилласан.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
"Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл" аяныг салбарын хэмжээнд хэрэгжүүлэхээр төлөвлөгөөг батлан төлөвлөгөөнд туссан арга хэмжээн салбарын хэмжээнд зохион байгуулж ажилласан.
2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:
Зам, тээврийн яамны дэргэдэх "Ёс зүйн дэд хороо"-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэхээр хурлын төлөвлөгөөг батлуулан 2025 оны ёс зүйн дэд хорооны 01 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн, батлуулж, төлөвлөгөөнд тусгасан үйл ажиллагааг заасан хугацаанд хэрэгжүүлж, Ёс зүйн зөрчил, гомдлыг хүлээн авч холбогдох хариуг хүргүүлэн ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт 3 гомдол ирснээс хоёр гомдлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариу өгч шийдвэрлэсэн ба нэг гомдлыг Зам, тээврийн яамны дэргэдэх ёс зүйн дэд хорооны 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар авч хэлэлцсэн. Иргэний нисэхийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны 25/03 дугаар дүгнэлтийг хүчингүй болгож шийдвэрлэсэн ба холбогдох шийдвэрийг гомдол гаргагч болон ёс зүйн дэд хороонд хүргүүлэн ажилласан байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Зам, тээврийн яамны дэргэдэх Ёс зүйн дэд хорооны гишүүнийг Монгол Улсын Ёс зүйн хороо, Удирдлагын академи хамтран зохион байгуулсан Ёс зүйн сургагч багш бэлтгэх нийт 32 цагийн хөтөлбөрт хамрагдан төгсөж 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн №251436 тоот үнэмлэх авсан байна. МУИХ-ын 2024 оны 27 дугаар тогтоолоор тогтоолоор батлсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг салбарын хэмжээнд суртачилан таниулсны хүрээнд салбарын хэмжээнд ёс зүйн зөрчил, гомдол, мэдээлэл багассан.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1-т гишүүнээр ажилласны төлөө урамшуулал авах" гэж заасан хэдийн ч Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүд, нарийн бичигт олгох ёстой урамшуулал нь Төрийн албаны ХНУМТ цахим системын урамшуулал гэсэн хэсэгт ороогүйгээс урамшуулал авахад хүндрэлтэй.

Санал:
Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулах тухай заалттай холбогдуулан цахим санд бүртгүүлэх хүсэлтээ Ёс зүйн хороонд илэрхийлсэн байгаа.

Шалгах хэсэг:

- ☐ "Ёс зүй, сахилга хариуцлагын үнэлгээний шалгуур үзүүлэлт"-ийн дагуу үнэлгээ хийсэн эсэх.
- ☐ Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд нийцүүлэн баталсан үйл ажиллагааны төлөвлөгөө хавсаргасан эсэх.
- ☐ Байгууллагын 2025 оны Ёс зүйн дэд хорооны хууль тогтоомжийн хэрэгжилтийн тайланг маягтын дагуу бүрэн тайлагнасан эсэх.

БАТАЛГААЖУУЛАЛТ:

Томилох эрх бүхий албан тушаалтан

Төрийн нарийн бичгийн дарга
/Албан тушаал/ *Гарын үсэг* Б.Насантогтох
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны дарга
Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
/Албан тушаал/ */Гарын үсэг/* Б.Болор-Эрдэнэ
/Гарын үсгийн тайлал/

Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
Салбарын хууль, эрх зүйн асуудал
хариуцсан мэргэжилтэн
/Албан тушаал/ */Гарын үсэг/* Т.Орхонтамир
/Гарын үсгийн тайлал/

Огноо: 2025 оны 12 дугаар сарын 26 -ны өдөр

"ШИНЭТГЭЛЭЭР ТҮҮЧЭЭЛСЭН САЛБАР ЗӨВЛӨЛ" АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025-06-12

Ажлын нэр: 3.2Төрийн албан хаагчдын судалгаа, шинжилгээ, дүн шинжилгээ хийх, баримт бичиг боловсруулах, цахим хэрэглээний ур чадварыг сайжруулах ажил, сургалтыг үе шаттай зохион байгуулж, 2-оос доошгүй удаа уралдаан, мэтгэлцээн, тэмцээн явуулах;

Багийн чиглүүлэгч: М.Энхболд-Салбарын хяналтын газрын дарга

Багийн гишүүд: З.Цэрэнгомбо-БТГ-ын мэргэжилтэн З.Цэрэнгомбо

Ц.Наранчимэг-ТЗДТБЗГ-ын шинжээч

Б.Билэгжаргал-ТЗУГ-ын СХ-ийн ахлах мэргэжилтэн

Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аяныг зохион байгуулах тухай 15 дугаар тушаалын хавсралтаар баталсан удирдамжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд багийн гишүүд хийх ажлаа хуваарилан төлөвлөгөө боловсруулж багийн чиглүүлэгчээр хянуулав.

Дээрх ажлын хүрээнд сургалтыг цахим хэлбэрээр нийтэд хүртээмжтэй, байнга ашиглаж байх давуу талтай байхаар сургалтын аппликэйшн хийж нийтэд санал болгоод байна.Одоогийн байдлаар энэхүү аппликэйшнд логик сэтгэлгээ, Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, Монгол бичгийн гарын авлага зэрэг 200 гаруй ном сурах бичиг, Excel, Word, ArcGis гэх мэт программын сургалтын гарын авлагыг оруулаад байна.Мөн яамны албан хаагчид өөрсдийн хэрэглэж байгаа гарын авлага бусад материалыг оруулж бусадтайгаа хуваалцаж байхаар шийдлийг орууллаа.

Одоогийн байдлаар төлөвлөсөн ажлын дараагийн шат болох цахим уралдааныг логик сэтгэлгээний чиглэлээр явуулахаар төлөвлөөд байна.

___ООО___

"ШИНЭТГЭЛЭЭР ТҮҮЧЭЭЛСЭН САЛБАР ЗӨВЛӨЛ" АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2025-05-28

3.2Төрийн албан хаагчдын судалгаа, шинжилгээ, дүн шинжилгээ хийх, баримт бичиг боловсруулах, цахим хэрэглээний ур чадварыг сайжруулах ажил, сургалтыг үе шаттай зохион байгуулж, 2-оос доошгүй удаа уралдаан, мэтгэлцээн, тэмцээн явуулах гэсэн зааltын хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах мэргэжилтэн	Тайлбар
1	Цахим хэрэглээ, баримт бичиг боловсруулалт болон бусад сургалтын материалыг агуулсан вэбийг яамны хэмжээнд хийж байнгын ашиглах	2025-05-28 2025-06-10	З.Цэрэнгомбо	Бүх төрлийн хэрэглээний программ ашиглах гарын авлага, архив, бичиг хэрэг хөтлөлт болон бусад нээлттэй болон хязгаарлагдмал эх сурвалжийн материалыг байршуулсан байна.
2	Архив бичиг хэрэг хөтлөлтөөр цахим уралдаан зохин байгуулах	2025-05-28 2025-06-10	Ц.Наранчимэг Б.Билэгжаргал	Дээрх сургалтын гарын авлагаас сэдэвлэж 2-3 асуултаас бүрдсэн байна. Хамгийн зөв хариулсан эхний 2 ялагчийг үнэ бүхий зүйлээр шагнана.
3	Цахим хэрэглээ, дүн шинжилгээний талаар IQ сорил уралдааныг хялбар хөгжөөнт байдлаар зохион байгуулах	2025-05-28 2025-06-10	Ц.Наранчимэг Б.Билэгжаргал	Энэ сэдвийн хүрээнд сэтгэлгээний 2-3 асуултаас бүрдсэн байна. Хамгийн зөв хариулсан эхний 2 ялагчийг үнэ бүхий зүйлээр шагнана.

Хянасан чиглүүлэгч: СХГ-ын дарга М.Энхболд

ТАЗ-өөс “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аяны хүрээнд энэхүү сургалтын хэсгийг зориулж байна.Та бүхэн мөн өөрт байгаа гарын авлага материалаас оруулж бусадтайгаа хуваалцахыг хүсье. Чиглүүлэгч: СХГ-ын дарга М.Энхболд

Агуулга:

Тайлбар:

Нэр:

Хавсралт файл:

Choose File No file chosen


Илгээх

Сургалтын мэдээлэл

Агуулга	Тайлбар	Нэр	Хавсралт файл
Гарын авлага	Анхан шат томьёоны хувилбарууд орсон	Excel 2022	Татах
Гарын авлага	Гарын авлага	Word	Татах
Гарын авлага	Гарын авлага	Ecxel	Татах
Гарын авлага	Гарын авлага	Ecxel	Татах
Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь	Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс эрхлэн гаргасан.	Толь бичиг	Татах
Гарын авлага	Эргэцүүлэн бодохдоо рациональ, логик байр сууринаас ханддаг болоход тус нэмэр болно.	Логик	Татах
Word	гарын авлага	Билэгжаргал	Татах
ArcGIS программ	Энэхүү программ нь орон зайн мэдээлэл боловсруулахад авто замын салбарт чухал ач холбогдолтой	ArcGis	Татах
Excel сургалт	Excel сургалтын 15 хичээлийн линк оруулав. google account-аар нэвтэрч орно уу	Цахим сургалт	Татах
ХАА-ны шалгалтын тест	Хамгийн сүүлийн хувилбар хариултын хамт	Шалгалтын тест	Татах
Excel makpo	Excel.mn-ээс эрхлэн гаргасан зарим нэг номын хэсгээс оруулав./зохиогчийн эрхтэй болохыг анхаарна уу/	excel	Татах
Түүхэн зураг	Авто тээвэртэй холбоотой	Гэрэл зураг	Татах
Төрөл бүрийн номууд	Энэ 206 номыг та бүхэн арилжааны зориулалтаар олшруулан ашиглахгүй байхыг хүсье	Номууд	Татах
Монгол бичиг	Төрийн албан хаагчдад зориулсан	Монгол бичиг гарын авлага	Татах
Албан хэрэг хөтлөлт	Нийтлэг журам	Тушаал 214	Татах



Enkhbold.M



Логик сэтгэлгээ

Та доорх асуултад хариулснаар ном хожих боломжтой

tinyurl.com

5

Өдрийн мэнд. ТАЗ-н "Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл" аяны хүрээнд 3.2 /З.Цэрэнгомбо, Ц.Наранчимэг, Б.Билэгжаргал/-р хэсгээс доорх тааврыг Та бүхний дунд явуулж байна. Зөв хариулсан эхний 1 оролцогчийг Төрийн шагналт, Соёлын гавьяат зүтгэлтэн Д.Төрбатын "Хаан төрийн нууц" номоор урамшуулна. Та бүхэн идэвхтэй оролцоно уу Энэ линкээр https://tinyurl.com/taavar орж, бөглөнө үү.



7

Хамгийн түрүүн зөв хариултыг ирүүлсэн Э.Жаргалсайхандаа баяр хүргэе.

5:01 PM

4

Нэгтгэл

Timestamp	Email Address	Таны нэр	Хоёр аав, хоёр хүү 3 загас барьжээ.Гэхдээ	Логик дараалыг
6/16/2025 15:29:15	badamsurenmrtd18@gr	Э.Бадамсүрэн	өвөө аав хүү гурав байсан.	40
6/16/2025 15:30:30	jagaa.jacky99@gmail.co	Э.Жаргалсайхан	Өвөө аав хүү 3	96
6/16/2025 15:30:57	javbayartsetseg@gmail.	т.жавхлан	Өвөө, аав, ач хүү гурав.	8*11+8=96
6/16/2025 15:31:52	oyuka7417@gmail.com	Д.Оюунсүрэн	Өвөө аав хүү 3 байсан байна	40
6/16/2025 15:32:16	gerelee.su@gmail.com	Ц.Хосгэрэл	Өвөө, аав, хүү 3 байсан.	96
6/16/2025 15:33:02	battsetsegb109@gmail.	Б.Батцэцэг	Өвөө, аав, хүү 3- 2 нь аав, 2 нь хүү. Нийт 3 хүн	40
6/16/2025 15:33:18	bayanzul.l@gmail.com	Л.Баянзул	Өвөө, аав, хүү 3	40
6/16/2025 15:33:54	summitub@gmail.com	У.Мөнхцэцэг	Өвөө, түүний хүү, ач хүү байсан нь 2 аав 2 хүү г	40
6/16/2025 15:33:56	erdenezayamrtd@gmail	Баярсайханы Эрдэнэз	Өвөө, аав, хүү	42
6/16/2025 15:34:02	dondogbayarmaa@gma	Баярмаа	Өвөө, аав, хүү 3	40
6/16/2025 15:34:10	dbodisaikhan@gmail.co	Бодьсайхан	өвөө, аав, хүү 3.	96
6/16/2025 15:38:06	jargaaaa@gmail.com	Жаргал	Өвөө, аав, хүү 3 байсан.	96
6/16/2025 15:38:34	nasantogtokhb@gmail.c	Бадрах Насантогтох	Өвөө аав хүү	40
6/16/2025 15:40:33	dbodisaikhan@gmail.co	Д.Бодьсайхан	Гурван хүн байсан: Өвөө (нэг аав) Аав (нэг аав	96
6/16/2025 15:41:55	munkherdene053@gma	Мөнх-Эрдэнэ	Аав, хүү, өвөө 3	40
6/16/2025 15:45:46	zthya2025@gmail.com	Бямбасүрэн	Өвөө, аав, хүү гурван хүн байсан	40
6/16/2025 15:47:16	soyolmaagsony88@gma	г.соёлмаа	аав хүү өвөө 3 байсан бна тэхлээр 2 аав 2 хүү (	102
6/16/2025 15:49:20	baigal20000@gmail.cor	Б.Байгалмаа	Өвөө, аав, хүү	40
6/16/2025 15:49:52	lhashinechimeg@gmail.	Л.Шинэчимэг	өвөө, хүү, ач хүү 3	40
6/16/2025 15:53:33	oyunjargal.ja@gmail.cor	Оюунжаргал	хүү, хүүгийн аав, хүүгийн өвөө	96
6/16/2025 15:54:59	myagaamos@gmail.cor	Мягмарсүрэн	Өвөө, аав, хүү гурав байсан	96
6/16/2025 15:56:26	erde9888@gmail.com	С.Эрдэнэчимэг	өвөө, хүү, ач/3/	40
6/16/2025 15:59:08	zagdradnaa@gmail.com	Загдраднаа	Аав, өвөө, хүү 3	106
6/16/2025 16:01:44	zagdradnaa@gmail.com	Д.Загдраднаа	Өвөө, аав, хүү 3	96

"ШИНЭТГЭЛЭЭР ТҮҮЧЭЭЛСЭН САЛБАР ЗӨВЛӨЛ" АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2025-06-10

Ажлын нэр: Ахмад төрийн албан хаагчидтай уулзалт зохион байгуулан мэдлэг, туршлагыг хуваалцах арга хэмжээг 6-аас доошгүй байгууллагатай хамтран зохион байгуулах;

Багийн гишүүд: Д.Хишигбаатар- СХГ-ын ахлах мэргэжилтэн

Б.Булганбаяр – ИНБЗГ-ын ахлах мэргэжилтэн

Ө.Одгэрэл - БТГ-ын ахлах шинжээч

Ш.Хавидолда- АТБЗГ-ын шинжээч

Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын баталсан Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн “Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл” аяныг зохион байгуулах тухай 15 дугаар тушаалын хавсралтаар баталсан удирдамжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 1.3 дахь заалтйн хүрээнд багийн гишүүд хийх ажлаа хуваарилан ахмад төрийн албан хаагчидтай уулзалт, арга хэмжээг зохион байгуулав.

___ООО___

АХМАД ТӨРИЙН АЛБАН ХААГЧИДТАЙ УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАН МЭДЛЭГ, ТУРШЛАГЫГ ХУВААЛЦАХ АРГА ХЭМЖЭЭ

1	Төрийн соёрхолт, Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн, Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд асан Цэрэнпилийн Гомбосүрэн 2025.04.18 өдөр хийсэн уулзалт, ярилцлага	
2	2025.05.02-ны өдрийн 09:00-10:00 цагийн хооронд/-ийн Мэдээллийн цагаар “Дайчилгааны тухай хууль”, “Орон нутгийн хамгаалалтын тухай төлөвлөгөө” сэдвээр уулзалт Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, бригадын генерал Ж.Болдбаатар	

3	Монгол Улсын 25 дахь Ерөнхий Сайд, дипломат С.Баяр 2025.05.09-ний өдрийн 08:30 цагт Зам, тээврийн яамны Их нүүдэл танхимд албан хаагчидтай уулзалт	
4	Онц бөгөөд бүрэн эрхт элчин, доктор (Ph.D) В.Энхболд “АНУ-ын тарифын бодлого, зохицуулалт” сэдвээр 2025.05.09-ны 10 цагаас Зам, тээврийн яамны Их нүүдэл танхимд албан хаагчидтай уулзалт	

5	Гадаад, худалдааны эдийн засагч, доктор (Ph.D) МУИС-ын багш Н.Батнасан “Олон улсын харилцаа ба тарифын бодлого, зохицуулалт” сэдвээр 2025.05.09-ны 11 цагаас Зам, тээврийн яамны Их нүүдэл танхимд албан хаагчидтай уулзалт	
6	2025.05.21-ний өдрийн 8.30 цагийн “Мэдээллийн цаг арга хэмжээ”-нд УИХ-ын дарга асан, Монгол улсын гавьяат хуульч, Хууль зүйн ухааны доктор, профессор Жамсрангийн Бямбадорж “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа, хандлага” сэдэвт уулзалт	

БАТЛАВ.
БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН
ДАРГА БӨГӨӨДЭС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Б.БОЛОР-ЭРДЭНЭ

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 03 дугаар сарын 02-ны өдөр

№	Хийх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
1	Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг албан хаагчдад сурталчлах ажлыг зохион байгуулах.	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
2	“Төрийн албан хаагчийг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг сурталчлах ажлыг зохион байгуулах	3 дугаар улиралд	Ёс зүйн дэд хороо
3	Албан хаагч нарт “Өнөөгийн Монголын нийгмийн ёс суртахууны тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдвээр сургалт зохион байгуулах.	1 дүгээр улиралд	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга
4	“Байгууллагын соёл, ёс зүйг дээшлүүлэх” арга хэмжээний удирдамжийг батлуулж, хэрэгжилтийг хангах	2 дугаар улиралд	Ёс зүйн дэд хорооны гишүүд
5	Байгууллагын соёл, ёс зүйн байдалд үнэлгээ хийж, зөвлөмж өгөх.	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны гишүүд
6	Байгууллага, хувь хүний соёлтой холбоотой /“Мэндлэх соёл”, “Монголын уламжлалт зан заншил, харилцаа”, “Хүн байхын учир” “Хувь хүний хөгжил, өөрийгөө бүтээх зам” “Хувь хүний харилцааны ур чадвар”, “Хувцаслах соёл”, “Ёс зүйн хандлага” гэх мэт/ болон бусад хамаарах сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулж мэдлэг түгээх.	2-3 дугаар улиралд	Ёс зүйн дэд хорооны гишүүд
7	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлах ажлыг зохион байгуулах.	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны гишүүд.
8	Зам, тээврийн хөгжлийн яамны албан хаагчдад “Гадаад орны ёс зүйн боловсролын туршлага” сэдвээр сургалт зохион байгуулах.	2 дугаар улиралд	Ёс зүйн дэд хорооны гишүүд
9	Төрийн албаны зөвлөлтэй хамтран ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах.	Жилдээ	Ёс зүйн дэд хорооны гишүүд

10	Гомдол, мэдээллийн дагуу албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан эсэх тухай асуудлыг хэлэлцэх, дүгнэлт гаргах, үйл ажиллагааг Ёс зүйн дэд хороонд тайлагнах, шаардлагатай тохиолдолд дүгнэлтийг Төрийн албаны салбар зөвлөлд танилцуулах.	Тухай бүр	Ёс зүйн дэд хороо
11	Шинээр томилогдсон алба хаагчдад "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалт зохион байгуулах.	2 дугаар улирал	Ёс зүйн зөвлөлийн дэд хорооны гишүүд, нарийн бичгийн дарга
12	Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа байгууллага болох Далайн захиргаа, "Гал тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв" УТҮГ, "Монголын төмөр зам" ТӨХК, Иргэний нисэхийн ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаатай танилцах, ёс зүйн дүрэм, ёс зүйн харилцаа хандлагын байдалд дүн шинжилгээ хийх, шаардлагатай тохиолдолд зөвлөмж өгөх, ёс зүйн дүрмийн талаар мэдээлэл өгөх.	2-4 дүгээр улиралд	Ёс зүйн дэд хороо
13	Ёс зүйн зөвлөлд гаргасан гомдол, мэдээлэл, дүгнэлт, хариуцлага тооцсон шийдвэрийг шийдвэрийг тухай бүр "Төрийн албаны хүний нөөцийн удирдлага, мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэн, мэдээллийн санд оруулах.	Тухай бүр	Ёс зүйн дэд хорооны нарийн бичгийн дарга.
14	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг дүгнэн, авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал дүгнэлт гаргах	4 дүгээр улиралд	Ёс зүйн дэд хорооны гишүүд

...oOo...

ТӨЛӨВЛӨСӨН:
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА: Т.ОРХОНТАМИР.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 03 сарын 22 өдөр Дугаар А/35 Улаанбаатар хот

Ёс зүйн зөвлөл шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 6.1, 6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус яамны албан хаагчдаас авсан нээлттэй санал асуулгын дүнг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх ёс зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:
Б.Болор-Эрдэнэ — Бодлого, төлөвлөлтийн газрын дарга

Нарийн бичгийн дарга:
Т.Орхонтамир — Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

Ажлын хэсгийн гишүүд:
С.Мяндасмаа — Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ц.Нэргүйбаатар — Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч

Ц.Баяржаргал — Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч

Д.Баярмаа — Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч

Ц.Эрдэнэ-Очир — Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн

П.Насанжаргал — Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн

2.Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх "Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам"-ыг хавсралтаар баталсугай.

080000283

3.Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Зөвлөлийн дарга (Б.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн “Ёс зүйн зөвлөл шинэчлэн байгуулах тухай” А/49 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн А/135 дугаар тушаалын хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам нь Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэн, хуулийн этгээдийн гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэ журам нь Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг /цаашид дүрэм гэх/ удирдлага болгоно.

Хоёр. Хамрах хүрээ

2.1.Энэхүү журам нь Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдад / цаашид албан хаагч гэх/ хамаарна.

2.2. Албан хаагчид Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг нэгэн адил чанд мөрдөнө.

Гурав. Ёс зүйн хэм хэмжээ

3.1.Төрийн захиргааны албан хаагч болон үйлчилгээний албан хаагч нь Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн Төрийн албан хаагчид тавих ёс зүйн шаардлага”-ыг албаны үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

Дөрөв. Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн

4.1. Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх Ёс зүйн зөвлөлийг /цаашид зөвлөл гэх/ Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар дарга, гишүүн, нарийн бичгийн дарга гэсэн бүрэлдэхүүнтэй байгуулна.

4.2.Зөвлөлийн гишүүд хуралдаанд саналын эрхтэйгээр оролцох бөгөөд саналаа илээр гаргана.

4.3. Зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдаанд бэлтгэх, хуралдааны зарыг нийт гишүүдэд мэдэгдэх, хуралдааны бэлтгэл ажлыг хангах, шийдвэрийн төслийг бэлтгэх үүрэг хүлээнэ.

Тав. Ёс зүйн зөрчлийн талаар мэдээлэл хүлээж авах, шалгаж шийдвэрлэх

5.1.Албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай гомдол, мэдээллийг зөвлөлийн нарийн бичиг хүлээн авч, зөвлөлийн даргад танилцуулж, шалгаж шийдвэрлэх ажиллагааг 14 хоногийн дотор явуулна.

5.2. Зөвлөлд ирүүлсэн гомдол мэдээлэл гаргагчийн нэр, хаяг заавал тодорхой байна.

5.3. Зөвлөлийн дарга хуралдааныг товлох бөгөөд ердийн олонхийн ирцтэй хуралдаж, гомдол мэдээллийг үндэслэлтэй гэж үзвэл зөрчлийн шинж байдлыг харгалзан зөрчил гаргачид хариуцлага хүлээлгэнэ.

5.4. Зөвлөлийн хуралдаанд гомдол, мэдээллийг шалгасан албан тушаалтан болон ёс зүйн зөрчилд холбогдсон албан хаагчийг биечлэн оролцуулж тайлбарыг сонсож, асуулт асууж, хариулт авч болно.

5.5. Зөвлөлөөс гарах дүгнэлтийг олонхын саналаар шийдвэрлэнэ.Санал тэнцсэн тохиолдолд даргын саналыг харгалзана.

5.6. Зөвлөлийн хуралдаанаас гарах дүгнэлт нь тогтоол хэлбэртэй байна.

5.7. Зөвлөлийн тогтоолыг гомдол гаргагч болон холбогдох албан хаагчид танилцуулна.

Зургаа. Ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

6.1. Албан хаагчдад энэхүү журмын 2.3-т заасан дүрмийн 4.2-т заасан хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Ёс зүйн зөвлөлийн тогтоолоор “уучлал гуйхыг үүрэг болгох” хариуцлага хүлээлгэсэн тохиолдолд уучлал гуйх хэлбэрийг тодорхой тусгана.

Долоо.Ёс зүйн зөрчлийн талаар тайлагнах, олон нийтэд мэдээлэх

7.1. Зөвлөл тухайн албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл гомдол, мэдээлэл, гаргасан иргэн, байгууллагад бичгээр хариу мэдэгдэнэ.

7.2. Албан хаагчид хариуцлага хүлээлгэсэн зөвлөлийн шийдвэрийг тухайн төрийн албан хаагчийн хувийн хэрэгт тэмдэглэж, байгууллагын дотоод сүлжээнд байршуулна.

7.3 Зөвлөл нь үйл ажиллагааны тайланг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлантай уялдуулан тухай бүр гаргана.

--oOo--

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Саид Төрийн нарийн бичгийн
даргын 2023 А/35 тоот тушаал

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 29 өдөр Дугаар А/86 Улаанбаатар хот

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.4.1, Монгол Улсын Ёс зүйн хорооны 2024 оны "Журам батлах тухай" 05 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-ын 2.4, 3.8-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тус яамны албан хаагчдаас авсан нээлттэй санал асуулгын дүнг үндэслэн Зам, тээврийн хөгжлийн яамны дэргэдэх "Ёс зүйн дэд хороо"-г дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	
Б.Болор-Эрдэнэ	Бодлого, төлөвлөлтийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	
Т.Орхонтамир	Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	
С.Мяндасмаа	Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга
Ц.Нэргүйбаатар	Автотээврийн бодлого зохицуулалтын газрын ахлах шинжээч
Ц.Баяржаргал	Автотээврийн бодлого зохицуулалтын газрын шинжээч
Д.Баярмаа	Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч
П.Насанжаргал	Төрийн захиргааны удирдлагын газрын шинжээч

2.Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг тухай бүр төлөвлөн зохион байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ёс зүйн дэд хорооны дарга (Б.Болор-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

6300006686

3.Ёс зүйн дэд хорооны дарга, гишүүдэд улиралд нэг удаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр, нарийн бичгийн даргад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 50 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг сар бүр олгохыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргад (Н.Цэвэлмаа)-т зөвшөөрсүгэй.

4.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн “Ёс зүйн зөвлөл шинэчлэн байгуулах тухай” А/35 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА С.БАТБОЛД

БАТЛАВ.
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАЛИЙН БИЧГИЙН ДАРГА
.....С.БАТБОЛД

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД 2023-2024 ОНД ШИНЭЭР ТОМИЛОГДСОН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

***Сургалтын хугацаа*:** 2024 оны 06 дугаар сарын 06-нд 14 цагт.
***Хаана*:** Хурлын 301 тоот.

№	Сургалтын сэдэв	Агуулга	Хугацаа	Хариуцан зохион байгуулах газар
1.	Төрийн албан хаагчийн баримтлах нийтлэг хэм хэмжээ	-Төрийн албан хаагчийн ёс зүйн шаардлага	20 мин	ТЗУГ ХХ
2.	Байгууллагын дотоод дүрэм журмын танилцуулга	Хөдөлмөрийн дотоод журмын агуулга, бүтэц -Байгууллагын нууцын журам -Албан хэрэг хөтлөлтийн журам	20 мин	ТЗУГ ХХ
3.	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн талаарх мэдээлэл	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчил шийдвэрлэх ажиллагаа	30 мин	ТЗУГ ХХ
4.	Хэвшмэл ойлголт ба харилцаа, хандлага	-Хэвшмэл ойлголт, харилцаа хандлага -Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуулийн агуулга	20 мин	ТЗУГ ХХ
5.	Нийтийн албан дахь ашиг сонирхлын зөрчил	Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь	10 мин	ХХ

--ооОоо—

БАТЛАВ.
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
.....С.БАТБОЛД

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Сургалтын зорилго:*Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа байгууллагын албан хаагчдад төрийн албан хаагчийн ёс зүй болон шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгөхөд оршино.*

Сургалтын хугацаа*: 2024.06.13-ны өдрийн 09 цагт*

Хаана*: ЗТХЯ-ны Хурлын 301 тоот.*

№	Хугацаа	Зохион байгуулах үйл ажиллагаа	Хариуцах албан тушаалтан
1	08:30-09:00	Харьяа байгууллагын албан хаагчдыг бүртгэх	Хуулийн хэлтэс
2	09:00-09:10	Сургалт нээж үг хэлэх	Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд
3	09:10-10:00	Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай	Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа
	10:00-10:10	Цайны завсарлага	
4	10:10-10:30	Захиргааны ерөнхий хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн зохицуулалт	Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа
5	10:30-10:50	Зам тээврийн салбарын Хүний эрх, Жендер, Хүүхэд хамгааллын дэд салбар зөвлөлүүдийн талаарх мэдээлэл	Хуулийн хэлтсийн дарга С.Мяндасмаа
6	10:50-11:00	Хаалт	

---oOo---

БАТЛАВ

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙД

С.БЯМБАЦОГТ

2024 оны 04 сарын 12 өдөр

ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ "БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ, ЁС ЗҮЙ" АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа байгууллага, ажилтан, албан хаагчдыг идэвхжүүлэх, байгууллага, хувь хүний соёл, ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах, хөгжүүлэх, туршлага солилцох, шинэ санаачилгыг дэмжихэд оршино.

Хоёр. Хамрагдах байгууллага

Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагууд;

Гурав. Ажиллах хугацаа

2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлж тайлагнах;

Дөрөв. Зохион байгуулах арга хэмжээ

- "Байгууллагын соёл, ёс зүйг дээшлүүлэх" удирдамжийн дагуу төлөвлөгөө гаргаж ажиллах,

- Байгууллага, хувь хүний соёлтой холбоотой "Мэндлэх соёл", "Монголын уламжлалт зан заншил, харилцаа", "Хүн байхын учир" "Хувь хүний хөгжил, өөрийгөө бүтээх зам" "Хувь хүний харилцааны ур чадвар", "Хувцаслах соёл", "Ёс зүйн хандлага" болон бусад хамаарах сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулж мэдлэг түгээх,

